




ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР

Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны
жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан
ДУАГ/2018/01-НТГ



Ус, рашааны нөөц ашигласны төлбөр, бууны албан татвар, газрын
дуудлага худалдааны орлогыг нэр төрлөөр бүрэн төвлөрүүлэх
шаардлагатай байна.

АГУУЛГА

<p>Тайланг бэлтгэсэн:</p> <p>Дундговь аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа</p> <p>Аудитын менежер: Х.Наранцацрал</p> <p>Ахлах аудитор: Т.Батсайхан</p> <p>Аудитор: Б.Гантуяа Ж.Угтахбаяр Т.Оюун-Эрдэнэ</p> <p>Аудитын тайлан, дүгнэлтгүй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 7059-3113 дугаарын угас, 70592439 дугаарын факсаар харилцана уу.</p> <p>ХАЯГ: Сайнцагаан сум 7-р баг, Нутгийн удирдлагын ордон, 210 тоот</p> <p>2018 оны 4 дүгээр сар</p>	<p>Товчилсон үгс</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО</p> <p>1.1 Төсвийн орлогыг УИХ-аас 2 удаа тодотгосон байна.</p> <p>1.2 Татварын орлого 1.2 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл 7 төрлийн орлого тасарсан байна.</p> <p>2 ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА</p> <p>2.1 Батлагдсан төсвийн 57 хувийг тусгай шилжүүлгийн зарлага эзэлж байна.</p> <p>2.2 Орон нутгийн төсвийн зардал зүйл бүрээр 81.9-99.9 хувийн гүйцэтгэлтэй, хэтрэлтгүй гарчээ.</p> <p>3. НЭМЭЛТ ТӨСӨВ</p> <p>Дүгнэлт Зөвлөмж Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал тайлбар Тайлан баталгаажуулах тушаал Тайлангийн хавсралтууд</p>	<p>3</p>
---	--	----------

ТОВЧИЛСОН ҮГС

УИХ	Улсын Их Хурал
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
ИОТТХ	Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний орлогын албан татвар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНО	Орон нутгийн орлого
ЗДН	Засаг даргын нөөц
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн, 2018 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн 04 дүгээр сарын 13-ны хооронд хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт:

Дундговь аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар нутгийн удирдах байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитын хамрах хүрээ:

Аудитад орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг дараах бүрэлдэхүүний хүрээнд хамруулав. Үүнд:

- Орон нутгийн төсвийн орлого
- Орон нутгийн төсвийн зарлага
- Нэмэлт төсөв

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлт:

Дараах хууль эрхийн актын холбогдох заалтыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглалаа. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Аудитын олон улсын стандарт, Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн болон санхүүгийн тайлангийн аудитын арга зүйг мөрдөж, байгууллагын холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитын судалгаа хийж, шаардлагатай горимыг хэрэгжүүлэн, нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор П.Төвсанаа хянан удирдаж, аудитын менежер Х.Наранцацрал үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн, Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор Т.Батсайхан, аудитор Б.Гантуяа, Т.Оюун-Эрдэнэ, Ж.Угтахбаяр нар гүйцэтгэсэн.

1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

1.1 Төсвийн орлогыг УИХ-аас 2 удаа тодотгосон байна.

УИХ-ын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр баталсан Монгол Улсын 2017 оны Төсвийн тухай хуульд Дундговь аймагт олгох санхүүгийн дэмжлэгийг 5,722.5 сая төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлгийг 2,635.1 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийг 22,756.8 сая төгрөгөөр тус тус баталж, тайлант онд Төсвийн тухай хуульд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна. Анхны батлагдсан төсвийг сүүлийн батлагдсан төсөвтэй харьцуулбал: (Хүснэгт 1)

№	Эх үүсвэрийн нэр	Хүснэгт 1. /сая төгрөгөөр/		
		УИХ-ын 2016.11.10	УИХ-ын 2017.10.26	Өссөн /+/, буурсан -/-
1	ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг	2,635.1	1,846.8	(788.3)
2	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	5,722.5	6,292.6	570.1
3	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	22,756.8	23,752.0	995.2
	Дүн	31,114.4	31,891.4	777.0

УИХ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлгийг 788.3 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийг 570.1 сая төгрөгөөр, тусгай шилжүүлгийн орлогыг 995.2 сая төгрөгөөр тус тус нэмж тодотгосон байна.

Тайлант онд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1,846.8 сая, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгээс 6,292.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгээр 23,752.0 сая төгрөгийн санхүүжилт тус тус батлагдсаныг бүрэн авсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэрийг төрлөөр харуулбал:

- Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгээр 23,752.0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, гүйцэтгэлээр 23,706.4 сая төгрөгийг зарцуулан, 45.6 сая төгрөгийг төвлөрүүлсэн.
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 1,846.8 сая төгрөг, улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн 6,292.6 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авч бүрэн зарцуулсан.

1.2 Татварын орлого 1.2 хувиар давж биелсэн боловч орлогын нэр төрлөөр авч үзвэл 7 төрлийн орлого тасарсан байна.

Тайлант онд орон нутгийн төсвийн нийт орлогыг 4,660.3 сая төгрөгөөр анх баталж, төсөвт дараах өөрчлөлтүүдийг оруулжээ. /Хүснэгт 2/

Хүснэгт 2 /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Төсөвт тодотгол хийсэн огноо дугаар			Өөрчлөлт	
		2016.12.02 Дугаар 11	2017.04.25 Дугаар 15	2017.11.15 Дугаар 24	(2-1)	(3-1)
		1	2	3	4	5
1	Татварын орлого	4,360.2	4,646.7	4,608.5	286.5	248.3
2	Татварын бус орлого	518.1	532.6	758.6	14.5	240.5
3	Төсөл сангийн орлого		3,887.3	3,165.9	3,887.3	3,165.9
4	Нийт орлого	4,878.3	9,066.6	8,533.0	4,188.3	3,654.7

Аймгийн ИТХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор нийт орлогыг 9,066.6 сая төгрөг, 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор орлогыг 8,533.0 сая төгрөг болгон тус тус тодотгосон байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дугаар сарын 15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор орлогын төлөвлөгөөг 8,533.0 сая төгрөгөөр баталсан. Үүнд татварын орлогыг 4,608.5 сая төгрөг, татварын бус орлогыг 3,821.5 сая төгрөг, хөрөнгийн орлого 103.0 сая төгрөгөөр тус тус баталжээ.

Татварын бус орлогын төлөвлөгөөний дүнд төсөл сангийн орлогын төлөвлөгөө 3,165.9 сая төгрөг орсон байна.

Аймгийн ИТХ-ын 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн тодотгол нь 2017 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулсантай холбоотой байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.1-д */Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх шаардлага зайлигүй бий болсон/* заасан шаардлагыг хангасан байна.

Тайлант хугацаанд 4,608.5 сая төгрөгийн татварын орлого бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 4,665.9 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 57.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. Үүнийг хүснэгтээр харуулбал: (Хүснэгт 3)

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хүснэгт 3 /сая төгрөгөөр/ Биелсэн
				/+/, Тасарсан /-/
1	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого	3,487.2	3,455.9	(31.3)
2	Үйл ажиллагааны орлого	348.7	415.4	66.7
3	Хөрөнгө борлуулсны орлого	103.0	126.2	23.2
4	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(436.7)	(436.7)	0.0
5	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	87.0	94.6	7.6
6	Бууны албан татвар	18.6	18.4	(0.2)
7	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	220.0	238.5	18.5
8	Улсын тэмдэгтийн хураамж	123.8	150.2	26.4
9	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	21.0	22.8	1.8
10	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	29.6	30.4	0.8
11	Газрын төлбөр	190.0	183.4	(6.6)
12	Дуудлага худалдаа	50.0	22.6	(27.4)
13	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	280.3	278.9	(1.4)
14	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	46.0	28.8	(17.2)
15	Бусад татвар	40.0	36.5	(3.5)
	Татварын орлого	4,608.5	4,665.9	57.4


Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн боловч дараах 7 нэр төрлийн орлого тасарсан байна. Үүнд:

- Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлогын төлөвлөгөөг 3,487.2 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,455.9 сая төгрөг төвлөрүүлж 31.3 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь цалин нэмэгдээгүй байхад өмнөх оноос төлөвлөгөөг 94.2 сая төгрөгөөр нэмж баталсантай холбоотой байна;
- Бууны албан татварыг 18.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 18.4 сая төгрөг төвлөрүүлэн, татварын орлого 0.2 сая төгрөгөөр тасарсан. Тайлант онд галт зэвсгийн албан татварын орлогыг өндөр төлөвлөсөн бөгөөд Цагдаагийн газарт бүртгэлтэй буу цөөн, галт зэвсгийн үзлэг явагдаж зөрчилтэй буунуудыг улсын орлого болгосонтой холбоотойгоор төлөвлөгөө тасарсан;
- Газрын төлбөрийг 190.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 183.4 сая төгрөг төвлөрүүлэн, төлбөрийн орлого 6.6 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь холбогдох албан тушаалтнууд холбогдох хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлж ажиллаагүйгээс шалтгаалсан байна;
- Дуудлага худалдааны орлогыг 50.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 22.6 сая төгрөг төвлөрүүлэн, орлого 27.4 сая төгрөгөөр тасарсан. Тайлант онд газрын дуудлага худалдаа зохион байгуулаагүй нь орлого тасрах шалтгаан болсон байна;
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөр 17.2 сая төгрөгөөр тасарсан нь аймгийн нутаг дэвсгэрт тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг уул уурхайн компаниудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсонтой холбоотой байна;

- Ан амьтны нөөц ашигласны төлбөр, бусад татварын орлогыг нийт 320.3 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 315.4 сая төгрөгийг төвлөрүүлэн 4.9 сая төгрөгөөр тасарсан байна. Орлого тасарсан шалтгаан нь орлогыг бодитой төлөвлөөгүйгээс гадна төлөвлөгөө биелүүлэх талаар дорвитой ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

Орлогын төлөвлөгөөний биелэлтийг нийт дүнгээр, сум тус бүрээр авч үзэхэд дунджаар 1.2 хувиар давж биелүүлсэн боловч татварын нэр төрлөөр авч үзвэл бууны албан татвар, ан агнуурын зэрэг орлогууд тасарсан байна. Сумдын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл, тасарсан орлого, түүний шалтгааныг хавсралт №1-д харууллаа.

Татварын орлогын төлөвлөгөөг сүүлийн 3 жилээр харьцуулахад 2016 онд 606.5 сая төгрөгөөр, 2017 онд 338.3 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Ус, рашааны нөөц ашигласны төлбөр сүүлийн 3 жил, бууны албан татвар, газрын дуудлага худалдааны орлого сүүлийн 2 жил дараалан тасарсан байна. /Хавсралт №3/



Иймд сумдад жил бүр тасарч байгаа дээрх нэр төрлийн орлогуудад судалгаа хийж, орлогыг бодитой төлөвлөх, цаашид орлогын төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

2. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГА

2.1 Батлагдсан төсвийн 57 хувийг тусгай ишлэжүүлгийн зарлага эзэлж байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 сарын 02-ны өдрийн 11 дугаар тогтоолоор төсвийн зарлагыг 35,726.9 сая төгрөгөөр баталж, 2017 оны 04 сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 5,740.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 41,467.2 сая, 2017 оны 11 сарын 15-ны өдрийн 24 дугаар тогтоолоор 829.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 42,296.5 сая төгрөг болгож тус тус тодотгожээ.

Хүснэгт 4:
/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Тодотгол хийгдсэн огноо		
		2016.12.02	2017.04.25	2017.11.15
1	Зарлага	35,726.9	41,467.2	42,296.5

УИХ болон аймгийн ИТХ-ын 2 удаагийн тодотголыг доорх графикаар харуулбал:



1. Орон нутгийн төсвийн зарлага:

Орон нутгийн төсвийг УИХ-аас 498.4 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-ын 2017 оны 04 сарын 25-ны өдрийн 15 дугаар тогтоолоор 23.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан.

2. ОНХС-ийн төсөв:

УИХ-аас 788.3 сая төгрөгөөр бууруулж, орон нутгийн давсан орлогын үлдэгдлээс 1,156.3 сая төгрөг, бусад эх үүсвэрээр 466.8 сая төгрөгөөр нэмэгдүүлж, хандив, өөрийн орлогыг 166.8 сая төгрөгөөр бууруулсан.

3. Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын зарлага:


УИХ-аас 1,261.1 сая төгрөгөөр, аймгийн ИТХ-аар 25.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

4. Төсөл сангийн төсөв:

Аймгийн ИТХ-аар 3,887.3 сая төгрөгөөр шинээр баталж, 2 дахь удаагийн тодотголоор 721.4 сая төгрөгөөр бууруулж 3,165.9 сая төгрөгийн төлөвлөгөөг баталсан байна./Хавсралт №2/

Батлагдсан төлөвлөгөөг сүүлийн 3 жилээр харьцуулахад 2017 онд өмнөх 2 жилээс ажиллагсадтай холбогдсон зардлын төлөвлөгөө 168.9-218.2 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын төлөвлөгөө 271.7-4,591.2 сая төгрөгөөр, татаас ба урсгал шилжүүлгийн төлөвлөгөө 73.5-782.4 сая төгрөгөөр нэмэгдэж, хөрөнгийн зардлын төлөвлөгөө 2,653.8-3,485.0 сая төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Төсвийн зарлага /сүүлийн 3 жилээр/





Батлагдсан төлөвлөгөөг бүтцээр нь авч үзвэл тусгай шилжүүлгийн зарлага 23,926.0 сая төгрөг буюу 57%, орон нутгийн төсвийн зарлага 11,848.1 сая төгрөг буюу 28%, ОНХС-ийн зарлага 3,356.4 сая төгрөг буюу 8%, төсөл сангуудын зарлага 3,165.9 сая төгрөг буюу 7%-ийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 5 /сая төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Анх батлагдсан	Тодотгосон төсөв	өсөлт, (бууралт)	Өсөлт, бууралтын нийт өөрчлөлтөд эзлэх хувь
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	18,010.3	18,437.1	426.8	50.4
2	Ажил олгогчоос төлөх НДШ	1,982.8	2,043.4	60.6	5.5
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,285.1	3,301.0	15.9	9.2
4	Хангамж, бараа материалын зардал	518.4	809.8	291.4	1.5
5	Нормативт зардал	1,827.5	1,438.4	(389.1)	5.1
6	Эд хогшил, урсгал засварын зардал	111.4	673.7	562.3	0.3
7	Томилолт, зочны зардал	93.1	171.1	78.0	0.3
8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ	818.7	868.6	49.9	2.3
9	Бараа үйлчилгээний бусад зардал	861.0	3,997.5	3,136.5	2.4
10	Урсгал шилжүүлэг	5,883.6	6,758.5	874.9	16.5
11	Хөрөнгийн зардал	2,335.0	3,797.4	1,462.4	6.5
дүн		35,726.9	42,296.5	6,569.6	100.0

Зардлыг нэр төрлөөр авч үзвэл нормативт зардал 389.1 сая төгрөгөөр буурч, бусад зардлууд 15.9-3,136.5 сая төгрөгөөр өссөн байна. Барааны үйлчилгээний зардал 3,136.5 хувиар өсөлттэй харагдаж байгаа нь төсөл сангийн зардлыг дээрх зардалд тайлагнасангай холбоотой байна.

2.2 Орон нутгийн төсвийн зүйл бүрээр 81.9 – 99.9 хувийн гүйцэтгэлтэй, зардал хэтрэлтгүй гарчээ.

Тайлант онд нийт зардлыг 42,296.5 сая төгрөгөөр төлөвлөж, 39,963.5 сая төгрөг буюу 94.5 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Хүснэгтээс харахад бараа үйлчилгээний бусад зардал, татаас ба урсгал шилжүүлгийн зардлын гүйцэтгэл 81.9-99.9 хувь байна.

Хүснэгт 6 /сая төгрөгөөр/

№	Нийт зардал	2017 он				
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэсэн (Хэтэрсэн)	Гүйцэтгэлийн хувь	Эзлэх хувь
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	20,480.5	20,454.6	25.9	99.9	51.2
2	Бараа үйлчилгээний бусад зардал	11,260.0	9,876.5	1,383.5	87.7	22.1
3	Татаас ба урсгал шилжүүлэг	6,758.5	6,522.5	236.0	96.5	12.6
4	Хөрөнгийн зардал	3,797.4	3,109.9	687.5	81.9	14.1
	Нийт дүн	42,296.4	39,963.5	2,332.9	366.0	100.0

Нийт зардлын бүтцийг диаграмаар харуулбал:



Гүйцэтгэлээрх нийт зардлын 51 хувийг ажиллагсадтай холбоотой зардал, 25 хувийг бараа үйлчилгээний бусад зардал, 16 хувийг татаас ба урсгал шилжүүлэг, 8 хувийг хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

Төсвийн үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулбал төлөвлөгөө 1,430.8 сая төгрөгөөр буурч, гүйцэтгэл 390.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7 /сая төгрөгөөр/

№	Урсгал зардал	2016 он		2017 он		Харьцуулалт өссөн +/- буурсан +/-	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Ажиллагсадтай холбогдсон зардал	20,311.6	20,270.7	20,480.5	20,454.6	168.9	183.9
2	Бараа үйлчилгээний бусад зардал	10,988.3	8,754.4	11,260.0	9,876.5	271.7	1,122.1
3	Татаас ба урсгал шилжүүлэг	5,976.1	4,970.2	6,758.5	6,522.5	782.4	1,552.3
4	Хөрөнгийн зардал	6,451.2	5,577.6	3,797.4	3,109.9	-2,653.8	-2,467.7
	Нийт дүн	43,727.2	39,572.9	42,296.4	39,963.5	-1,430.8	390.6

Харин бараа үйлчилгээний бусад зардал өмнөх оноос 1,122.1 сая төгрөгөөр өсч, хөрөнгийн зардал 2,467.7 сая төгрөгөөр буурсан байна.



2017 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан төсвийн зардлыг хэмнэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах зорилгоор батлагдсан УИХ-ын 29 дугаар тогтоолыг хэрэгжүүлж батлагдсан төсвийг хэмнэж ажилласан нь графикаас харагдаж байна.

3. НЭМЭЛТ ТӨСӨВ

Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогыг нэр төрлөөр бүртгэн, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, тайлагнажээ.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд 866.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, 858.2 сая төгрөгийг зарцуулж, 8.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны эх үүсвэрийн өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:


№	Нэмэлт төсвийн эх үүсвэр	Хүснэгт 8 / сая төгрөгөөр/		
		2016 он	2017 он	Өсөлт/ (Бууралт)
1	Орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж	3.6	24.7	21.1
2	Засгийн газрын нөөц хөрөнгө, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө	64.3	40.0	(24.3)
3	Дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид	626.0	654.1	28.1
4	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	67.5	91.9	24.4
5	Төсвийн урамшуулал	73.8	56.1	(17.7)
6	Өмнөх оны үлдэгдэл		-	-
Дүн		835.2	866.8	31.6

Судалгаанаас харахад санхүүжилт урьд оноос 31.6 сая төгрөгөөр өссөн байна.

Нэмэлт төсвийн орлогын бүтцийг диаграммаар харуулбал:

Нийт орлогын 75 хувийг дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид, 11 хувийг төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогод, 6 хувийг төсвийн урамшуулалд, 5 хувийг Засгийн газрын нөөц хөрөнгө, ЗДН хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгө, 3 хувийг орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламжаас тус тус бүрдэж байна.

Нэмэлт төсвийн зарлагын бүтцийг диаграмаар харуулбал:



Нэмэлт төсвийг бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал, хангамжийн бараа материалын зардлуудад 14-34 хувийг зарцуулсан нь зарцуулалтын ихэнх хувийг эзэлж байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтээ хийж байна. Үүнийг:

1. Улсын төсвийн тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт болон орон нутгийн төсвөөс санхүүжилтийг бүрэн авсан байна.
2. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээр давж биелсэн ч 7 нэр төрлийн орлогын төлөвлөгөө тасарчээ.
3. Төсөвт 2 удаа тодотгол хийж анхны тодотгосон төсвөөс 6 хувиар буурчээ.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн холбогдох албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн Засаг даргад:

1. Жил бүр тасарч байгаа нэр төрлийн орлогуудад судалгаа, дүгнэлт хийж орлогыг бодитой төлөвлөн, төлөвлөгөөг нэр төрөл тус бүрээр биелүүлэхэд анхаарч ажиллах

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛ, ТАЙЛБАР



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА

48090 Сайнцагаан сум, Дундговь аймаг,
Утас: 7059-2895, Факс: 7059-2895,
E-mail: info@dundgovi.gov.mn

2018.04.20 № 1/401
танай _____ -ны № _____ -Т

ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ


2017 оны Төсвийн ерөнхийлөн захирагчийн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын
тайлангийн төсөлд санал тайлбар байхгүй болно.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

*Баянгол улсын
Төсвийн гүйцэтгэлийн
Тайлангийн төсөлд
санал тайлбар байхгүй*



0200245

D:\Албан бичиг\2018 ЗДА5.docx

ТАЙЛАНГ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/18

Мандалговь

Г

Аудитын тайланг
баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 А/188 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 1.2, 2.4, 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан /ДУАГ-2018/1-СТА-ТЕЗ/-г баталсугай.


2. Аудитаар илэрсэн зөрчил, акт, албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3. “Дундговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлан”-д хийсэн аудитын тайланг Үндэсний аудитын газар болон аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.

4. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулан, үр дүнгийн талаар 2018 оны 09 дугаар сарын 25-ны дотор Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/, ерөнхий санхүүч /С.Энхжаргал/-д тус тус зөвлөсүгэй.

5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2018 оны 3 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Х.Наранцацрал/, Санхүүгийн аудитын албаны ахлах аудитор /Т.Батсайхан/ нарт үүрэг болгосугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



П.ТӨВСАНАА

ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

Т.БАТСАЙХАН

АУДИТОР

Б.ГАНТУЯА

Т.ОЮУН-ЭРДЭНЭ

Ж.УГТАХБАЯР

ТАЙЛАНГИЙН ХАВСРАЛТ

Хавсралт №1

Тасарсан орлогын судалгаа /Сумдаар/

№	Сум	ЕССЕН				Тасарсан орлогын төрөл	Тасарсан орлогын дүн	Тасарсан орлогын шалтгаан
		Телевлегее	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь			
1	Дэлгэрцогт	25,204.0	27,371.2	2,167.2	108.5	Бууны татвар	90.0	Орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй
						Хүү торгуулийн орлого	521.7	Орлогын төлөвлөгөөг биелүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй
2	Дэрэн	56,951.8	68,290.0	11,338.2	119.9	Бууны татвар	0.6	Бууны татварын орлогын төлөвлөгөө тасарсан нь бууны татвар 7.5 дахин өссөнтэй холбоотойгоор иргэд бугаа бүртгэлээс хасуулж Цагдаагийн байгууллагад хураалгаснаас шалтгаалсан
3	Цагаандэлгэр	32,106.7	35,667.9	3,561.2	111.1	Хүү торгуулийн орлого	0.04	Хадгаламжийн орлого буурснаас хүүгийн орлогын төлөвлөгөө тасарсан
						Хүү торгуулийн орлого	0.7	Тайлант онд татварын байцаагч 2 удаа солигдсон, энэ хугацаанд сар гаруй хугацаанд тасалдсан, иргэний бүртгэлийн ажилтангүй бүтэн жилийн хугацаанд Говь-Угтаал сумын ажилтан хавсран гүйцэтгэсэн зэрэг нь нөлөөлсөн.
4	Говь-Угтаал	48,918.9	64,287.5	15,368.6	131.4	Бууны татвар	6.0	Бууны татварын орлого тасарсан нь суманд бүртгэлтэй буунаас илүү, өндөр төлөвлөгөө өгсөнтэй холбоотой
5	Баянжаргалан	65,766.1	88,812.6	23,046.5	135.0	Байхгүй		Дүнгээрээ болон нэр төрлөөр төлөвлөгөө биелсэн

6	Өндөршил	25,917.3	31,413.8	5,496.5	121.2	Хүү торгуулийн орлого	746.8	Орлогын төлөвлөгөө өмнөх оноос 1.2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан, мөн цагдаагийн торгуулийн орлогоос өөр орлого төвлөрдөггүйтэй холбоотой байна.
7	Гурвансайхан	73,971.1	81,385.7	7,414.6	110.0	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	7,506.0	Орлогыг бодитой төлөвлөөгүй
						Хадгаламжийн хүүгийн орлого		Орлогыг бодитой төлөвлөөгүй
8	Елзийт	98,005.7	111,765.6	13,759.9	114.0	Агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	30,107.4	Орлогыг бодитой төлөвлөөгүй
9	Хулд	31,000.0	31,105.2	105.2	100.3	Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	5,198.1	Орлого бодитой төлөвлөгдөөгүй, мэргэжлийн хяналтын газраас жоншны үйл ажиллагааг хаасан тул орлого тасрах гол шалтгаан болсон байна.
						Төсвийн өөрийн орлого	66.3	
10	Луус	29,347.1	37,418.0	8,070.9	127.5	хог хаягдлын үйлчилгээний хураамж	163.2	Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй
11	Дэлгэрхангай	61,699.3	64,739.5	3,040.2	104.9	агнуурын нөөц ашигласны төлбөр, ан амьтан агнах, барих зөвшөөрлийн хураамж	4,333.7	Орлогыг бодитой төлөвлөөгүй
						Хог хаягдлын үйлчилгээний хураамж	846.0	Хууль тогтоомжийг мөрдөж ажиллаагүй

12	Сайхан-Овоо	29,609.0	36,277.6	6,668.6	122.5	Хүү, торгуулийн орлого	415.8	Орлого бодитой төлөвлөгдөөгүй, төсвийн өөрийн орлого бүрдүүлэх нөөц боломж муу, архивын үйлчилгээний орлого, ЗДТГ-ын буудлаас өөр орлого олох боломжгүй байгаа нь төлөвлөгөө тасрах шалтгаан болсон байна.
						Төсвийн өөрийн орлого	260.0	
13	Эрдэнэдалай	100,121.7	118,777.9	18,656.2	118.6	Байхгүй		
14	Сайнцагаан	243,759.9	271,901.3	28,141.4	111.5	Үйл ажиллагааны орлого /ИОТТХ/	2,190.7	ХХОАТ-ын тухай хуулиар хувиараа ажил, үйлчилгээ эрхлэгч иргэд өөрсдөө үйл ажиллагааны орлогыг тодорхойлж тайлагнадаг болсонтой холбоотой;
						Үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого	3,457.3	Орон сууцны худалдан авалт буурсантай холбоотой;
						ТТББА төлбөр	800.8	Өмнөх оноос барилга байшин цөөн баригдсантай холбоотойгоор төлбөр төлөгч иргэдийн тоо цөөрсөн;
						Бууны албан татвар	221.0	Татвар нэмэгдсэнтэй холбоотойгоор иргэд гал зэвсгээ устгах, худалдан борлуулснаас бүртгэлтэй бууны тоо цөөрсөн;
						Бусад орлого	664.7	Сумын төсөвт байгууллагын түрээсийн орлогыг тайлант онд аймгийн орон нутгийн орлогын дансанд төвлөрүүлдэг болсонтой холбоотой байна.
15	Адаацаг	34,824.3	46,403.6	11,579.3	133.3	Бусад орлого	440.6	Орлого бодитой төлөвлөгдөөгүй
Нийт дүн		957,202.9	1,115,617.4	158,414.5	1,769.9	-	58,037.4	

Хавсралт №2

Төсвийн тодотголоор хийгдсэн өөрчлөлт

№	Үзүүлэлт	Анхны батлагдсан төсөв	УИХ-аар тодотгосон	аймаг тодотгосон	2017 оны ОНО-ын эхний үлдэгдэл	2017.04.25 тодотгосон төлөвлөгөө	өөрчлөлт	УИХ-аар тодотгосон	аймаг тодотгосон	хандив, өөрийн орлого	2017.11.15 тодотгосон төлөвлөгөө	өөрчлөлт
1	Орон нутаг	10,398.90	-	23.0	763.3	11,185.2	786.3	498.4	164.6		11,848.2	663.0
2	ОНХС	2,688.50	(788.3)	442.8	1156.3	3,499.3	810.8		24.0	(166.8)	3,356.5	(142.8)
3	Тусгай шилжүүлэг	22,639.50	254.90	1.0		22,895.4	255.9	1,006.2		24.3	23,925.9	1,030.5
4	Төсөл сангууд			3,887.3		3,887.3	3,887.3			(721.4)	3,165.9	(721.4)
	дүн	35,726.9	-533.4	4,354.1	1,919.6	41,467.2	5,740.3	1,504.6	188.6	(863.9)	42,296.5	829.3

Хавсралт №3

Үзүүлэлт	2015		2016		2015/2016 оны өсөлт/+/- бууралт/-/	2017		2016/2017 оны өсөлт/+/- бууралт/-/
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхэлсний орлого	2,880.2	3,118.2	3,392.9	3,266.8	512.7	3,487.2	3,455.8	189.0
Үйл ажиллагааны орлого	270.2	330.3	312.8	407.7	42.6	348.7	415.4	7.7
Хөрөнгө борлуулсны орлого	138.0	118.1	110.9	124.2	(27.1)	103.0	126.2	2.0
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(348.2)	(348.2)	(430.2)	(430.2)	(81.9)	(436.7)	(436.7)	(6.5)
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	75.0	82.2	75.0	84.3	(0.0)	87.0	94.5	10.2
Бууны албан татвар	2.5	2.7	21.7	17.7	19.1	18.6	18.4	0.7
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	181.3	182.1	200.0	204.9	18.6	220.0	238.5	33.6
Улсын тэмдэгтийн хураамж	69.0	101.4	85.0	97.4	16.0	123.8	150.2	52.8
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	38.4	38.4	45.0	30.6	6.6	21.0	22.8	(7.8)
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	51.6	11.0	35.0	19.6	(16.6)	29.6	30.4	10.8
Газрын төлбөр	164.4	144.7	180.0	171.2	15.6	190.0	183.4	12.2
Дуудлага худалдаа	100.0	27.3	50.0	58.11	(50.0)	50.0	22.6	(35.5)
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	55.2	141.4	216.9	141.4	280.3	278.8	61.9
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	34.0	34.1	40.0	29.9	6.0	46.0	28.8	(1.2)
Бусад татвар	31.5	25.8	35.0	28.1	3.5	40.0	36.5	8.4
Татварын орлого	3,688.1	3,923.6	4,294.6	4,327.3	606.5	4,608.5	4,665.6	338.3